

“ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

Үндэслэл, тайлбар

Монгол Улсын Их хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр соёрхон баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх “Зөвшөөрлийн тухай” хуульд нийцүүлэн “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д дараах өөрчлөлтийг оруулахаар санал авч байна.

“Зөвшөөрлийн тухай” хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль хүчингүй болох юм.

Иймд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулиар зохицуулсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг “Зөвшөөрлийн тухай” хуульд нийцүүлэх шаардлагын үүднээс “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д дараах өөрчлөлтийг оруулахаар санал авч байна.

“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” нь Зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралтаар батлагдан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа юм.

№	Одоогийн заалт	Өөрчлөлт оруулах санал
1	1.2 Энэхүү нөхцөл, шаардлага нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль , холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцсэн байна.	1.2 Энэхүү нөхцөл, шаардлага нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн хууль , холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцсэн байна.
2	1.4 Төлбөртэй телевизийн үйлчилгээнээс бусад телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Зохицуулах хорооноос баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмыг баримтлана.	1.4 Төлбөртэй телевизийн үйлчилгээнээс бусад телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу нээлттэйгээр сонгон шалгаруулна.

3	1.8 Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль , Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл, шаардлага болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” -аар зохицуулна.	1.8 Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн хууль Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл, шаардлагаар зохицуулна.
4	2.5 Үйлчилгээний хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг баримтлах ба ирүүлсэн хүсэлтийг үнэлэхэд өрсөлдөөний нөхцөл байдал, дамжуулах сүлжээний багтаамж, техникийн боломж зэргийг харгалзан үзнэ.	2.5 Үйлчилгээний хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад ирүүлсэн хүсэлтийг үнэлэхэд өрсөлдөөний нөхцөл байдал, дамжуулах сүлжээний багтаамж, техникийн боломж зэргийг харгалзан үзнэ.
5	3.5 Энэхүү нөхцөл шаардлагын 2.4-д заасны дагуу хамрах хүрээнд нэмэлт, оруулахад хоёроос доошгүй жил аливаа зөрчилгүй ажилласан, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх нөхцөлийг хангана.	3.5 Энэхүү нөхцөл шаардлагын 2.4-д заасны дагуу хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад хоёроос доошгүй жил аливаа зөрчилгүй ажилласан, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх нөхцөлийг хангана.
6	3.8 Телевизийн нэрийг тусгай зөвшөөрөлд зааж, лого буюу баталгаажуулсан барааны тэмдгийг тусгай зөвшөөрлийн гэрээнд хавсаргах ба өөрчлөх тохиолдолд хүсэлтийг Зохицуулах хорооноос гаргасан маягтын дагуу ирүүлж , тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулна.	3.8 Телевизийн нэрийг тусгай зөвшөөрөлд зааж, лого буюу баталгаажуулсан барааны тэмдгийг тусгай зөвшөөрлийн гэрээнд хавсаргах ба өөрчлөх тохиолдолд хүсэлтийг Зохицуулах хороонд гаргаж , тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулна.